



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2025 оны 02 сарын 26 өдөр

Дугаар 105

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дүгээр зүйлийн 2, 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 16 дэх заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.3, 4.4, 4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар (Цахим хөгжил, инноваци, харилцаа холбооны сайдын багц) санхүүжүүлж бий болгосон, нийт 6,373,712,734.00 (зургаан тэрбум гурван зуун далан гурван сая долоон зуун арван хоёр мянга долоон зуун гучин дөрөв) төгрөгийн үнэ бүхий барилга байгууламжийг хавсралтад заасны дагуу Дархан-Уул аймгийн өмчид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч П.Алтан-Од, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Д.Бат-эрдэнэ нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх, бүртгэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийг байнгын ашиглалтад хүлээн авсан улсын комиссын акт, санхүүжилт хийснийг баталгаажуулан эрх бүхий байгууллагын шийдвэр, зориулалтыг харгалзан хүлээлцэх, хавсралтад заасны дагуу Засаг даргын тамгын газарт эзэмшүүлэх, бүртгэх асуудлыг шийдвэрлэх;

2.3. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл удирдлага зохицуулалтын цахим систем”-д бүртгэх

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2025 оны 2 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгооугай.


ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Д.НАРАНГЭРЭЛ



УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР БИЙ БОЛСОН ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ӨМЧИД
БҮРТГЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Төсөл, арга хэмжээний хүчин чадал	Гүйцэтгэлээрх хөрөнгийн дүн (төгрөг)	Улсын комиссын акт	
				Огноо	Дугаар
1	“Мэдээлэл холбооны Дархан дэд төв”-ийн барилга (Дархан-Уул аймаг, Дархан сум 1,2,3-р баг)	А блок 45.0*15.0 м хэмжээтэй, 2 давхар, Б блок 30.0*15.0 м, цутгамал төмөр бетон хийцлэлтэй, чулуун болон шилэн фасадтай бармлга	6,373,712,734.00	12/2/2024	39/2024-Д
	Нийт дүн		6,373,712,734.00 (зургаан тэрбум гурван зуун далан гурван сая долоон зуун арван хоёр мянга долоон зуун гучин дөрөв)		